



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 177

танай _____ -ны № _____ -т

**ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.МӨНХБАЯР ТАНАА**

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж тайлан, гэрчилгээг хүргүүлэв.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
УДИРДЛАГА
ДАРГА
Ш.МӨНХБАЯР
2025.03.25 17:57



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/4/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.МӨНХБАЯР ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 177
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Шарын гол сумын ТЭЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус сумын 2024 оны орлогыг 2,797.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 2,995.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 7.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдсэнээр цалингийн зардал өмнөх оноос 67.6 хувиар өссөн байна.

4525020303

Бусад асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг Шарын гол сумын ИТХ-аар хэлэлцээд, "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,844,281,934.26	1,670,905,655.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	716,907,798.55	654,454,951.03
33	АВЛАГА	310,259,663.31	580,782,697.38
35	БАРАА МАТЕРИАЛ	235,377,839.40	373,430,751.82
36	НӨӨЦИЙН БАРАА	43,157,510.00	45,601,010.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	538,579,123.00	16,636,245.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,240,613,804.49	4,327,236,946.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,240,613,804.49	4,327,236,946.44
39200	Биет хөрөнгө	3,234,602,763.41	3,904,578,690.30
39300	Биет бус хөрөнгө	6,011,041.08	422,658,256.14
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,084,895,738.75	5,998,142,601.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	68,498,694.25	141,346,669.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,498,694.25	141,346,669.80
41300	Өглөг	68,498,694.25	141,346,669.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,016,397,044.50	5,856,795,931.87
51	Засгийн газрын хувь оролцоо	5,016,397,044.50	5,856,795,931.87
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,033,665,203.54	981,754,783.54
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,033,665,203.54	981,754,783.54
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	55,187,200.00
51200	Хуримтлагдсан үр дүн	3,137,112,697.10	3,974,234,804.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	845,619,143.86	845,619,143.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,084,895,738.75	5,998,142,601.67



2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,956,493,639.73	7,242,264,854.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,162,990,493.57	2,995,323,392.22
110	Орлогын албан татвар	1,910,707,125.82	2,708,965,251.23
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,910,707,125.82	2,708,965,251.23
113	Хөрөнгийн албан татвар	72,308,929.75	90,542,529.27
118	Бусад татвар, төлбөр, хураамж	179,974,438.00	195,815,611.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	750,224,318.98	648,774,682.08
120	Нийтлэг татварын бус орлого	750,224,318.98	648,774,682.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,043,278,827.18	3,598,166,780.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,785,363,632.70	4,745,065,295.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,785,363,632.70	4,745,065,295.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,319,294,135.22	4,167,616,564.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	989,668,760.29	1,553,868,907.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,126,494.83	192,636,008.54
2104	Хангамж, бараа материалын зардал	93,005,990.09	66,659,685.37
2105	Нормативт зардал	60,053,069.95	74,668,280.44
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,999,770.00	144,292,151.21
2107	Томилолт, зочны зардал	4,406,000.00	7,956,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,243,059.56	120,373,361.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,815,247,618.17	612,223,040.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,466,069,497.48	577,448,730.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,171,130,007.03	2,497,199,559.05
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,116,501,787.00	1,656,800,671.68
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,054,628,220.03	840,398,887.37



2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,033,665,203.54	845,619,143.86	2,082,484,477.07	3,961,768,824.47
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,033,665,203.54	845,619,143.86	2,082,484,477.07	3,961,768,824.47
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,054,628,220.03	1,054,628,220.03
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,033,665,203.54	845,619,143.86	3,137,112,697.10	5,016,397,044.50
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,033,665,203.54	845,619,143.86	3,137,112,697.10	5,016,397,044.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,033,665,203.54	845,619,143.86	3,137,112,697.10	5,016,397,044.50
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	3,276,780.00	-	(3,276,780.00)	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	840,398,887.37	840,398,887.37
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,036,941,983.54	845,619,143.86	3,974,234,804.47	5,856,795,931.87



2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,390,463,125.25	6,397,811,696.13
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,162,990,493.57	2,995,323,392.22
110	Орлогын албан татвар	1,910,707,125.82	2,708,965,251.23
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,910,707,125.82	2,708,965,251.23
113	Хөрөнгийн албан татвар	72,308,929.75	90,542,529.27
118	Бусад татвар, төлбөр, хураамж	179,974,438.00	195,815,611.72
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,741,360.00	24,382,800.00
1181	Газрын төлбөр	165,233,078.00	171,079,881.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0	352,930.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	581,015,668.40	683,230,983.91
120	Нийтлэг татварын бус орлого	581,015,668.40	683,230,983.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,646,456,963.28	2,719,257,320.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,356,067,885.09	4,371,970,363.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,356,067,885.09	4,371,970,363.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,890,260,387.61	3,793,491,633.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	942,327,352.54	1,553,868,907.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,845,087.29	192,636,008.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,735,620.29	1,394,939,129.77
2104	Хангамж, бараа материалын зардал	196,274,697.82	198,672,506.03
2105	Нормативт зардал	0	340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,572,770.00	165,258,912.00
2107	Томилолт, зочны зардал	4,158,000.00	7,956,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,005,014.00	128,371,491.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,405,341,845.67	151,448,677.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,465,807,497.48	578,478,730.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,034,395,240.16	2,025,841,332.48
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,710,701,190.00	2,088,294,180.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,710,701,190.00	2,088,294,180.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,710,701,190.00	2,088,294,180.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,710,701,190.00)	(2,088,294,180.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(204,940,000.00)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	204,940,000.00	-
230001	Эргэж төлөгдөх зээл	204,940,000.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	118,754,050.16	(62,452,847.52)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	598,153,748.39	716,907,798.55
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	716,907,798.55	654,454,951.03



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,588,678,700.00	5,472,505,596.34	(1,116,173,103.66)	83.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,751,149,500.00	3,443,797,716.34	(307,351,783.66)	91.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,609,149,600.00	3,313,958,985.84	(295,190,614.16)	91.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,359,334,900.00	1,254,585,744.95	(104,749,155.05)	92.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,601,400.00	156,565,791.54	(17,035,608.46)	90.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,505,535,700.00	1,360,939,129.77	(144,596,570.23)	90.4
2104	Хангамж, бараа материалын зардал	52,359,100.00	51,674,938.72	(684,161.28)	98.7
2105	Нормативт зардал	3,300,000.00	340,000.00	(2,960,000.00)	10.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	205,553,500.00	205,195,212.00	(358,288.00)	99.8
2107	Томилолт, зочны зардал	8,412,000.00	7,956,000.00	(456,000.00)	94.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,415,800.00	122,953,491.86	(19,462,308.14)	86.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,637,200.00	153,748,677.00	(4,888,523.00)	96.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,999,900.00	129,838,730.50	(12,161,169.50)	91.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	66,000,000.00	63,883,398.00	(2,116,602.00)	96.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,999,900.00	65,955,332.50	(10,044,567.50)	86.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,583,522,800.00	2,028,707,880.00	(554,814,920.00)	78.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	254,006,400.00	-	(254,006,400.00)	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,588,678,700.00	5,740,750,948.65	(847,927,751.35)	87.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,340,469,700.00	2,188,007,800.00	(152,461,900.00)	93.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,705,588,200.00	3,401,849,940.34	(303,738,259.66)	91.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	542,620,800.00	150,893,208.31	(391,727,591.69)	27.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	164,614,080.34		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	432,859,432.65		



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,976,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,976,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,366,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,748,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,418,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,610,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,610,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,976,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,976,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,896,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,080,000.00



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шарын гол сумын ТЕЗ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн захиргааны удирдлага, үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэгтэй, Дархан-Уул аймгийн ТЕЗ-д харьяалагдана.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сумын ТЕЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэсэн төсвийн шууд захирагч бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 913.2 сая төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	716.9	654.5	(62.4)
Авлага	310.2	580.8	270.6
Бараа материал	235.4	373.4	138.0
Нөөцийн бараа	43.2	45.6	2.4
Бусад эргэлтийн хөрөнгө	538.6	16.6	(522.0)
Үндсэн хөрөнгө	3,240.6	4,327.2	1,086.6

Нийт хөрөнгө	5,084.9	5,998.1	913.2
Өр төлбөр	68.5	141.3	72.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,016.4	5,856.8	840.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,084.9	5,998.1	913.2

Мөнгөн хөрөнгө 62.4 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны мөн үеэс орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 345.1 өгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Харин авлагын дансны 270.6 сая төгрөгийн өсөлтөд ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалтыг авлагаар бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материал 138.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 309.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 111.2 сая төгрөгийн “Шарын гол сумын эртний түүх соёлын дурсгалын нэгдсэн бүртгэл судалгаа”, “Шарын гол сумын түүхэн аялал жуулчлалын баримт бичиг”, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг бүртгэж, урсгал үйл ажиллагаанд 283.1 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Өмнөх онд төсвийн жил дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтыг бүртгэсэн “бусад эргэлтийн хөрөнгө” данс тайлант онд хэрэгжсэн дүнгээр буурсан байна.

Үндсэн хөрөнгө 1,086.6 сая төгрөгөөр өссөн нь тус сумын ЗДТГ-т Онцгой байдлын газраас 106.9 сая төгрөгийн автомашиныг шилжүүлэн авсан, сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 910.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн 2.2 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авснаас голлон шалтгаалжээ.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний чанарын баталгааны барьцаа хөрөнгө 100.6 сая төгрөгөөр, байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 11.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Тулга сувилал” ОНӨААТҮГ-ын дансны өглөгийн 36.7 сая төгрөгөөр, бусад байгууллагын өр төлбөр 2.1 сая төгрөгөөр буурснаас нэгтгэсэн тайлан дахь өр төлбөрийн данс 72.8 сая төгрөгөөр нэмэгджээ.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 840.4 сая төгрөгийн тайлант оны үр дүнгээр өссөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 323.6 сая төгрөг болж, өмнөх оноос 423.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0.0	0.0	0.0
Банканд байгаа бэлэн мөнгө	716.9	654.5	(62.4)
Төгрөг	716.9	654.5	(62.4)
Төрийн сангийн харилцах	627.9	562.1	(65.8)
Арилжааны банк дахь харилцах	89.0	92.4	3.4
Дүн	716.9	654.5	(62.4)

Эх сурвалж: Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 654.5 сая төгрөгийн 562.1 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 92.4 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцахад байгаа 562.1 сая төгрөгийн 67.7 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 195.3 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 237.5 сая төгрөг нь

хоршоо хөгжүүлэх сангийн, 61.6 сая төгрөг нь байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа дансны үлдэгдэл бөгөөд арилжааны банкин дахь 92.4 сая төгрөг нь “Тулга сувилал” ОНӨААТҮГ-ын дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Шарын гол сумын ЗДТГ үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 4.4 сая төгрөгийн балансын урамшуулал олгосон, 10.0 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу, 3.2 сая төгрөгийн өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлгийг илүү тайлагнасан,
- Тус сумын ИТХ 3.0 сая төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй, 0.1 сая төгрөгийг зардал хооронд шилжүүлэн зарцуулсан,
- “Тулга сувилал” ОНӨААТҮГ 0.5 сая төгрөгийн цалин илүү олгосон, зах зээлийн үнээс 1.9 сая төгрөгөөр илүү үнээр мах бэлтгэсэн, тодруулга тайланд 481.5 сая төгрөгийн зардлыг бөөн дүнгээр бичсэн, худалдан авалтын 0.8 сая төгрөгийн цахим төлбөрийн баримт зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 494.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3.8 сая төгрөгийн зөрчлийг даван гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 580.8 сая төгрөг болж, өмнөх оноос 270.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас санхүүжилтийн авлага	1.0	358.8	357.8
Зээлийн хүүгийн авлага	4.5	2.9	(1.6)
Дансны авлага /ТӨҮГ/	4.0	8.1	4.1
Байгууллагаас авах авлага	0.0	10.0	10.0
Хувь хүмүүсээс авах авлага	300.7	201.0	(99.7)
Дүн	310.2	580.8	270.6

Эх сурвалж: Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс үзэхэд ОНӨААТҮГ-ын дансны авлага 4.1 сая төгрөгөөр, ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалтын аймгаас авах авлага 357.8 сая төгрөгөөр, ЗДТГ-ын байгууллагаас авах авлага 10.0 сая төгрөгөөр өссөн бол Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой зээлийн хүүгийн авлага 1.6 сая төгрөгөөр, зээлийн авлага 99.7 сая төгрөгөөр тус тус буурчээ.

Нийт авлагын 61.8 хувийг ОНХС-ийн авлага, 35.1 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн авлага, 1.7 хувийг төсөвт байгууллагын авлага, 1.4 хувийг ОНӨААТҮГ-ын авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.4.3 Бараа материал

Нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 235.4 сая төгрөг байснаас оны эцэст 373.4 сая төгрөг болж, 138.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	13.7	16.7	3.0
Тусгай зориулалттай материал	0.0	0.5	0.5
Эм боох материал	13.7	16.2	2.5
Хангамжийн материал	221.7	356.7	135.0
Бичиг хэргийн материал	43.9	149.3	105.4
Аж ахуйн материал	146.4	169.0	22.6
Сэлбэг хэрэгсэл	0.3	2.5	2.2
Түлш, шатах тослох материал	1.3	1.3	0.0
Барилгын засварын материал	1.6	2.4	0.8
Хүнсний материал	13.5	16.2	2.7
Бусад хангамжийн материал	14.7	16.0	1.3
Дүн	235.4	373.4	138.0

Эх сурвалж: Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 21.2 хувь нь ОНӨААТҮГ-т, 78.8 хувь нь төсөвт байгууллагад бүртгэлтэй байна.

Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон сумын түүхэн баримт бичиг, нэгдсэн судалгаа, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг ЗДТГ-т бүртгэж авсан нь бараа материалын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,327.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,086.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,234.6	3,904.6	670.0
Барилга, байгууламж, орон сууц	780.0	751.4	(28.6)
Авто-тээврийн хэрэгсэл	54.7	144.1	89.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	110.7	134.8	24.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	34.1	59.9	25.8
Зам гүүрийн байгууламж	283.7	237.7	(46.0)
Бусад үндсэн хөрөнгө	1,890.1	2,495.4	605.3
Дуусаагүй барилга байгууламж	79.5	79.5	0.0
Ном	1.8	1.8	0.0
Биет бус хөрөнгө	6.0	422.7	416.7
Программ хангамж	1.6	1.2	(0.4)
Бусад биет бус хөрөнгө	4.4	421.5	417.1
Дүн	3,240.6	4,327.3	1,086.7

Эх сурвалж: Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 99.0 хувь нь төсөвт байгууллагуудад, 1.0 хувь нь ОНӨААТҮГ-т бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 90.2 хувийг биет хөрөнгө, 9.8 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Шарын гол сумын ЗДТГ 385.1 сая төгрөгийн газрыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй,
- Шарын гол сумын ИТХ 3.0 сая төгрөгийн дахин үнэлсэн хөрөнгийг бусад орлогоор бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх алдааг аудитын явцад залруулсан байна.

3.4.5 Өр төлбөр

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 68.5 сая төгрөг байснаас тайлант онд 72.8 сая төгрөгөөр өсөж, оны эцэст 141.3 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.7	2.2	1.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.9	0.0	(0.9)
Байгууллагад төлөх өглөг	18.9	129.5	110.6
Хувь хүмүүст төлөх өглөг	1.9	1.7	(0.2)
Татварын өглөг /ТӨҮГ/	0.4	1.0	0.6
Дансны өглөг /ТӨҮГ/	45.7	6.9	(38.8)
Дүн	68.5	141.3	72.8

Эх сурвалж: Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 92.8 хувь нь төсөвт байгууллагуудад, 7.2 хувь нь ОНӨААТҮГ-т бүртгэлтэй байна.

ОНХС-ийн тайланд хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний чанарын баталгааны барьцаа хөрөнгийн өр төлбөр нийт өр төлбөрийн 71.2 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөр данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,856.8 сая төгрөг болж, өмнөх оноос 840.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	1,033.7	981.8	(51.9)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.0	55.2	55.2
Хуримтлагдсан үр дүн	3,137.1	3,974.2	837.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	845.6	845.6	-
Дүн	5,016.4	5,856.8	840.4

Эх сурвалж: Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс 51.9 сая төгрөгөөр буурсан нь ОНӨААТҮГ-ын өмчийг аудитын явцад аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дансанд залруулан бүртгэсэнтэй холбоотой.

Хуримтлагдсан үр дүн тайлант үеийн ашгаар нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Засгийн газрын хувь оролцоо данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ОНХС-ийн орлогыг 2,246.4 сая төгрөгөөр, татварын болон татварын бус орлогыг 2,430.2 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлийг 200.0 сая төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг 259.0 сая төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 910.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 6,045.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг сумын ИТХ хэвээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсвийг тайлант хугацаанд 2 удаа тодотгож, санхүүжих эх үүсвэр болон зарлагыг 542.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 6,588.6 сая төгрөгөөр тодотгосон байна. Тодотголоор ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга хэмжээг 352.1 сая төгрөгөөр, ИТХ-ын санхүүжилтийг 21.0 сая төгрөгөөр, ЗДТГ-ын санхүүжилтийг 169.3 сая төгрөгөөр, ерөнхий боловсролын сургуулиудын ашиглалтын зардлыг 0.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ. Энэ нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр ОНХС-аас 2,188.0 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвийн орлогоор 3,401.8 сая төгрөгийн, үйл ажиллагааны орлогоор 150.9 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,472.5 сая төгрөг буюу 83.1 хувьтай байгаа нь ЗДТГ-т 4 орон тоо дутуу ажилласнаас цалин, НДШ-ийг зардлыг дутуу зарцуулсан, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудын тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, ХХС-аас зээл олгоогүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 592.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажил хэрэгжээгүйгээс дараа онд шилжсэн зэргээс голлон шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шарын гол сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх онд төвлөрүүлсэн 1.0 сая төгрөг, тэргүүний шилдэг сумын урамшуулал 10.0 сая төгрөг, тендерийн орлого 1.1 сая төгрөг, мал тооллогын 0.7 сая төгрөг, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 0.2 сая төгрөгийн, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 12.0 сая төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн сумын ИТХ-ын суудалтай намуудад олгосон дэмжлэгтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Шарын гол сумын Засаг дарга 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 01/100 дугаар албан бичгээр 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТЕЗ-ийн 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 6,588.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 98.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Иймд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шарын гол сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой зөвлөмж хүргүүлснийг биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 8. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	179.4	2	179.4	100
Нийт дүн	2	179.4	2	179.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80.2 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд “Тулга сувилал” ОНӨААТҮГ-ын 55.2 сая төгрөгийн өмчийг төсвийн байгууллагын дансанд ангилал зөрүүлэн бүртгэсэн нь

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

УСНББОУС1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС 6 “Нэгдсэн ба тусдаа санхүүгийн тайлан”-тай нийцэхгүй, “Ангилал”, “Толилуулга” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул Засгийн газрын оруулсан капитал данснаас хасаж, төрийн өмч /ТӨҮГ/ дансанд тусгуулж залруулав.

- Шарын гол сумын ЗДТГ-ын тэжээлийн нөөцийг бусад нөөц дансанд ангилал зөрүүлэн бүртгэсэн нь УСНББОУС1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС 6 “Нэгдсэн ба тусдаа санхүүгийн тайлан”-тай нийцэхгүй, “Ангилал”, “Толилуулга” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул тэжээлийн нөөц дансанд тусгуулж залруулав.

Аудитаар 35.4 сая төгрөгийн зөрчил² илэрсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

Шарын гол сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 35.4 сая төгрөгийн дэмжлэг олгосон нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д “энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”, 34 дүгээр зүйлийн 34.6.3-т “Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно: төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аудитын тайлан хүргүүлсэн өдрөөс хойш орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусгаан илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

³ Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	2	80.2			2	80.2	2	80.2				
ЗДТГ	3	398.4	1	385.1	2	13.3	3	398.4				
ИТХ	2	3.1			2	3.1	2	3.1				
Тулга сувилал	1	481.5			1	481.5	1	481.5				
Дүн	8	963.2	1	385.1	7	578.1	8	963.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	1	35.4					1	35.4				
ЗДТГ	2	149.1			1	4.4	1	144.7				
ИТХ	1	3.0					1	3.0				
Тулга сувилал	3	3.2	2	2.4			1	0.8				
Дүн	7	190.7	2	2.4	1	4.4	4	183.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
ЗДТГ	1	144.7						1	144.7
Дүн	1	144.7						1	144.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1	144.7						1	144.7

7. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	2			2			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ОНТС	2	1	1		1			
4	ОНӨҮГ	1	1			1			
5	ТЕЗ	1	1			1			
	НИЙТ	6	5	1		5			